

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


Хянасан:

Л.Дулмаа /Тамгын газрын дарга/

Боловсруулсан:

Г.Өлзийдэлгэр /Хүний нөөц хариуцсан
шинжээч, ЭБАТ/

Б.Ариунзаяа /Хуулийн зөвлөх, шинжээч/



Улаанбаатар хот 2015 он

УДИРТГАЛ

Авлигын эсрэг хууль, Төрийн аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Үндэсний аудитын газрын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын хэмжээнд:

- Авлигын эрсдлийг бууруулах, шударга ёс ил тод байдлыг хангах
- Төсвийн болон худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах,
- Иргэдийн өргөдөл, гомдол хүлээн авах шийдвэрлэх,
- Мэдээлэл хүргэх ажиллагааг боловсронгуй болгох,
- Авлигын эсрэг, шударга ёсны талаар сурталчилгаа, авлигын эсрэг нөлөөллийн ажлыг зохион байгуулах зэрэг ажлыг нэн тэргүүний зорилт болгон төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж ажиллаа.

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үндэсний аудитын газраас Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах үүднээс 2015 оны 01 сарын 30-ны өдөр Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, Монгол Улсын Ерөнхий аудиторoor батлуулж, АТГ-т хүргүүлсэн.

Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө нь:

1/ хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хэрэгжүүлэх ажил

2/Авлигаатай тэмцэх санал, санаачлага гэсэн 2 бүлгээс бүрдэж байгаа болно.

Хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил

Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2.

1.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/

Авлигын эсрэг хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудас, дотоод мэдээллийн сан, мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбоотой УИХ-аар хэлэлцэгдэх хууль, бусад шийдвэр, бодлогын баримт бичгийн төсөлд санал авах, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэхийн тулд Засгийн газрын IV дүгээр байрны 1 давхарт Үндэсний аудитын газрын мэдээллийн самбарт иргэдийг хүлээн авах цагийн хуваарь, өргөдөл, гомдол гаргахад тавигдах шаардлага, санал хүсэлтийн хайрцаг ажиллуулж байна.

Мөн Үндэсний аудитын газарт 2015 онд байгууллагын цахим хуудас /www.audit.mn/-ны санал хүсэлт хүлээн авах цэс, байгууллагын цахим шуудан /info@audit.gov.mn/, болон бичгээр нийт 101 /2015 оны 11 сарын 10-ны байдлаар/ өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснийг холбогдох журмын дагуу бичиг хэрэгт бүртгүүлэн, удирдлагын цохолтоор холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлэн, хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

1.2.Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийт албан тушаалтнуудад сургалчилах зорилгоор Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах тухай 120 ширхэг, авлигаас татгалзах, соён гэгээрүүлэх зурагт хуудас 400 ширхэг, бусад гарын авлага 210 ширхэгийг I, III улиралд тарааж иргэд, байгууллага, албан хаагчдад түгээж ажилласан.

Гарын авлага, тараах материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад хүргэж ажилласнаар авлига гарах эрсдэлийн талаар албан хаагчдад таниулах, мэдээлэл хүргэх, шударга бус явдлыг таслан зогсоох, авлигаас ангид байх нөхцөл бүрдэх үр дүнтэй ажил болсон. /Материал тараасан тухай бүртгэлийг хавсаргав/



Зураг 1 Үндэсний аудитын газрын мэдээллийн самбар



Зураг. 2 Гарын авлага тараасан байдал



Зураг.3 Гарын авлага тараасан байдал

Хоёр. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5

2.1.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх.

2015 онд Төрийн аудитын байгууллагаас УИХ-аар хэлэлцэгдэх хууль, бусад шийдвэр, бодлогын баримт бичгийн төсөл гараагүй бөгөөд цаашид төсөл боловсрогдох тохиолдолд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн саналыг тухай бүр цахим болон санал асуулга хэлбэрээр авч, саналыг тусгаж ажиллана.

Харин бусад байгууллагаас 2015 онд шинэчлэн боловсруулагдаж буй 7 хуулийн төсөлд санал өгсөн байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Аудитын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай,

- Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлал,
- Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай
- Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай
- Хяналтын тухай хуулийн төсөл

Гурав. Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3

3.1. Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх.

Үндэсний аудитын газраас 2015 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 01 сарын 05-ны өдрийн 05 тоот тушаалаар батлагдсан бөгөөд audit.mn цахим хуудаст байршуулсан.

Төлөвлөгөөний дагуу аудит хийгдэж, баталгаажуулсан Аудитын тайланг тухай бүр цахим хуудаст тогтмол байршуулж олон нийтэд мэдээлж байна. 2015 онд хийгдсэн нийт /2014 оны төсвийн зарцуулалтад хийсэн/ Санхүүгийн аудитын 59 тайлан, Гүйцэтгэлийн аудитын 6 тайлан, Нийцлийн аудитын 7 тайланг тус тус цахим хуудаст тухай бүр бүрэн эхээр нь байршуулаад байна. / www.audit.mn сайтын Аудитын тайлан меню-ээс үзнэ үү/

Мөн МҮЕА-ын 2014 оны 03 сарын 28-ны өдрийн 125 дугаар тушаалаар "Төрийн аудитын байгууллагын мэдээллийн ил тод байдлын журам" батлагдан гарч мөрдөн ажиллаж хэвшээд байна. / www.audit.mn сайтын Авлигаас урьдчилан сэргийлэх меню-ээс үзнэ үү/

3.2. Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/

Аудитын үйл ажиллагаа, төлбөрийн акт, албан шаардлага, түүний биелэлтийн талаар тогтмол цахим хуудаст байршуулж, мэдээлэн ажиллаж байгаа бөгөөд байгууллагын цахим хуудсанд байршуулсан, 2015 оны тухайд төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрөлжсөн болон орон нутгийн харьяа аудитын газар /21 аймаг, нийслэл/-аар жилийн эцэст нэгтгэн мэдээлэх ажил хийгдэж байгаа. Нэгтгэлийн мэдээг цахим хаягт жил бүр байршуулдаг ба 2015 оны нэгтгэлийг оны эцэст батлагдсан үед байршуулахаар төлөвлөн ажиллаж байна. /Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлсэн байдал, оролцсон нэвтрүүлэг, ярилцлага өгсөн жагсаалтыг хавсаргав/

3.3.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх

Аудитын үйл ажиллагаа, акт, албан шаардлага, түүний биелэлтийн талаар тогтмол цахим хуудаст байршуулж, мэдээлэн ажиллаж байна. /мэдээллийг www.audit.mn цахим хуудаснаас үзнэ үү/

Дөрөв. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4: Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дахь заалт,

4.1 Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/

Төсвийн тухай хуулийн 8.4, 8.6 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу Төсвийн төслийг төлөвлөн Сангийн яам, УИХ-ын Төсвийн байнгийн хороогоор хянуулан нийт 3,2 тэрбум төгрөг үүнээс:

Цалингийн зардал 1,9 тэрбум төгрөг

Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл 0,2

Бараа үйлчилгээний зардал 0,6 тэрбум төгрөг

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 0,4 тэрбум төгрөг

Татаас ба урсгал шилжүүлэг 0,06 турбум төгрөгөөр тус тус батлуулан ажиллаж байна.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Төсөв гүйцэтгэл хэсгийн

2. Тухайн жилийн төсөв, орлого, урсгал зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр

4.2 Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх заалтын дагуу Жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг гарган хараат бус аудитын байгууллагаар баталгаажуулан ажиллаж байна.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Төсөв гүйцэтгэл хэсгийн 5. Жилийн эцсийн санхүүгийн тайлан

4.3 Сарын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь заалтын дагуу сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг гарган, баталгаажуулан ажиллаж байна.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Төсөв гүйцэтгэл хэсгийн 3. Төсөв ба гүйцэтгэл.

4.5 Хагас жилийн санхүүгийн тайлан /8 дугаар сарын 15-ны дотор/

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх заалтын дагуу хагас жилийн санхүүгийн тайланг гарган ажиллаж байна.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Төсөв гүйцэтгэл хэсгийн 5. Жилийн эцсийн санхүүгийн тайлан.

4.6 Дараа жилийн төсвийн төсөл /9 дүгээр сарын 15-ны дотор/

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтын дагуу төсвийн төслийг боловсруулан Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Төсөв гүйцэтгэл хэсгийн 6. Дараа жилийн төсвийн төсөл

4.7 Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.

Төрийн аудитын тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу Улсын Их Хурлын даргын томилсон хараат бус мэргэжлийн аудиторoor жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэн, дүнг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулан, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Төсөв гүйцэтгэл хэсгийн 7. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

4.8. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар

Үндэсний аудитын газар нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд хэтрэлт гардаггүй. Хэмнэлт үүссэн тохиолдолд шаардлагатай зардал руу эдийн засгийн ангилал шилжүүлэх, төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай Засгийн газрын тогтоолын дагуу тодотголоор зардлыг хасуулах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Зарим үед төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс зарим зардал хэмнэлттэй харагдаж байгаа нь улсын төсвийн орлого тасарч санхүүжилтын эрх нээгдээгүй зардлууд байдаг. Мөн өмнөх жилийн хэмнэлт, хэмнэлтийн зарцуулалтын талаар мэдээлдэг.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Төсөв гүйцэтгэл хэсгийн 3. Төсөв ба гүйцэтгэл

Төсөв гүйцэтгэл хэсгийн 4. Төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан зардлын тайлан

4.9 Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор/

Тухайн жилийн батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийг Сангийн яамнаас албан ёсны мэдээлэл ирсний дараа сайтад мэдээлдэг. Одоогийн байдлаар мэдээлэл ирээгүй байгаа болно.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Төсөв гүйцэтгэл хэсгийн 8. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт

4.10 Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/

Үндэсний аудитын газрын актын төлбөр шууд улсын төсөвт төвлөрдөг бөгөөд тус газар нь зөвхөн байгууллагууд төлбөрөө тушаасан эсэхэд хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг.

Нэмэлт орлогын дансанд аудитын төлбөрийг төвлөрүүлдэг бөгөөд төлбөр орсон тухай бүрт өссөн дүнгээр мэдээлдэг.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү . Хөрөнгө оруулалт хэсгийн 2. Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа/

4.11. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/

Үндэсний аудитын газарт хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж байхгүй болно.

4.12. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт /гүйлгээ хийснээс 7 хоногийн дотор/

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш гүйлгээнүүдийг хуулийн хугацаанд иж бүрдлийг ханган мэдээлдэг.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү . Төсөв гүйцэтгэл хэсгийн 9. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт /

4.13. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/

Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг тухай бүрт мэдээлэн ажиллаж байна. Үндэсний аудитын газар нь 2014 оны 11 дүгээр сард бүтцийн өөрчлөлт орсон бөгөөд Монгол Улсын ерөнхий аудиторовын 314 дугаар тушаалыг мөрдөн ажиллаж байна. Дээрх өөрчлөлтөөс хойш байгууллагын батлагдсан орон тоонд өөрчлөлт ороогүй болно.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү. Байгууллага хэсгийн 3. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт

4.14. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр /батлагдсанаас хойш 7 хоногийн дотор/

Үндэсний аудитын газарт Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс зэрэг байхгүй болно. Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг хуулийн хугацаанд мэдээлэн ажиллаж байна.

4.15. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний талаарх хэрэгжилтийн мэдээлэл

Үндэсний аудитын газарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр 2015 оны байдлаар хараахан байхгүй байгаа ба цаашид төсөл хөтөлбөр хэрэгжих үед холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах болно.

Мэдээллийг www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү . Байгууллага хэсгийн 1. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан

Тав. Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах

Төрийн аудитын байгууллага нь Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгодоггүй.

Зургаа. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл

6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/

Сул орон тооны зарыг тухай бүр өөрийн байгууллагын цахим хуудас www.audit.mn болон дотоод мэдээллийн сан, бусад сонин сэтгүүлд байршуулан ажиллаж байна. Сул орон тооны тухай зарыг 2015 онд тухай бүр сайт болон мэдээллийн самбарт зарласан. /www.audit.mn сайтын ил тод байдал меню-ээс үзнэ үү/

6.2. Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх

Сонгон шалгаруулалт явуулах талаар тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын цахим хуудсаар ил тод зарлахын зэрэгцээ сонгон шалгаруулалт явуулах зарыг тухай бүр байршуулдаг. /www.audit.mn сайтын Ил тод байдал хэсгээс үзнэ үү/

Долоо. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5

7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах /1 дүгээр сарын 10-ны дотор/

Үндэсний аудитын газрын 2015 оны төсөвт хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй бөгөөд хуульд зааснаар тухайн онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хугацаанд нь эрх бүхий байгууллагад хүргүүлж ажилласан.

2015 онд Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа нь байрны түрээсийн төлбөрийг зардлын эдийн засгийн ангилалыг өөрчлүүлэн урсгал засварын зардлыг санхүүжүүлэх тухай хүсэлтийг Сангийн яаманд албан бичгээр хандаж /2015 оны 03 сарын 16-ны өдрийн 566 тоот албан бичгийг хавсаргав/ холбогдох зөвшөөрлийг авсаны дагуу Үндэсний аудитын газарт 2015 онд худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг батлуулж, батлуулсан даруй Сангийн яамны Хууль худалдан авах ажиллагааны бодлогын газарт төлөвлөгөөг хүргүүлэн /2015 оны 05 сарын 13-ны өдрийн 866 тоот албан бичгийг хавсаргав/ Худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас болон байгууллагын цахим хуудсанд байршуулсан. /www.e-procurement.mn болон www.audit.mn сайтаас үзнэ үү/

7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерийн урилгыг хуулийн хугацаанд худалдан авах ажиллагааны цахим хуудас, байгууллагын цахим хуудас болон олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр /өдрийн сонин/ зарлан мэдээлсэн болно. /Холбогдох баримтыг хавсаргав/

7.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах

Тендер шалгаруулалтын талаарх явц, дүн болон тендерт шалгарсан шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэлийн талаарх шалтгаан, мэдээллийг хууль, тогтоомжид заасны дагуу хугацаанд нь худалдан авах ажиллагааны цахим хуудас болон байгууллагын цахим хуудас /шилэн данс хэсэг/-д мэдээлэн ажилласан. /www.e-procurement.mn болон www.audit.mn сайтаас үзнэ үү/

7.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр хуулийн хугацаанд нь байршуулан ажиллаж байна. /www.audit.mn сайтын Шилэн данс меню-ээс үзнэ үү/

7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах

Үндэсний аудитын газрын 2015 оны худалдан авах ажиллагаанд аудит хараахан хийгдээгүй байна. Мөн Худалдан авах ажиллагааг тайлагнах журамд заасны дагуу Үндэсний аудитын газрын 2015 оны худалдан авах ажиллагааны тайланг 2016 оны 01 сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлэх бөгөөд тайлангийн үнэлгээ ирмэгц байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллана.

7.6. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгчийг оролцуулан худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод, шударга явуулах нөхцөл боломжийг хангаж ажиллаа. /Үнэлгээний хороо байгуулах тухай тушаалыг хавсаргав/

Найм. Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6

8.1. Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх

Төрийн аудитын тухай хуульд 2013 оны 11 сард нэмэлт, өөрчлөлт орсноор Төрийн аудитын байгууллага босоо тогтолцоонд /орон нутгийн аудитын газрууд нь УАГ-ын харьяа болж, улсын төсвөөс санхүүждэг болсон/ шилжсэн тул МУЕА-ын 2014.04.02-ны өдрийн 127 дугаар тушаалаар "Ажлын байрны тодорхойлолтод үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулах" ажлын хэсэг байгуулагдан ажилласан. 2014 онд аймаг, нийслэлийн аудитын газрын ажилтнуудын, 2015 онд Үндэсний аудитын газрын төрөлжсөн аудитын газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг тус тус шинэчлэн боловсруулж, МУЕА-аар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

8.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох

Албан хаагч бүрийн хариуцсан ажил үүргийн талаарх мэдээллийг нээлттэй болгох зорилгоор нийт ажилтнуудын албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг www.audit.mn сайтын хүний нөөцийн ил тод байдал цэсэд байршуулсан. Ажил үүргийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлснээр Төрийн аудитын байгууллагад ажиллах сонирхолтой иргэд, харилцагч байгууллага, албан тушаалтан мэдээлэлтэй болох ба тухайн албан хаагчийн ажил үүргийн талаар хууль ёсны шаардлага тавих нөхцөл бүрдэж байна. /www.audit.mn сайтын ил тод байдал меню-нээс үзнэ үү/

Ес. Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3

Төрийн албанд хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэ шатанд хүргэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг тэдэнд олгох, шударга ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, хуулиар хүлээсэн үүргээ төгс биелүүлэх замаар авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн төлөвлөсөн хүрээнд биш байгууллага, салбар, орон нутгийн онцлогт тохирсон илүү өргөн хүрээнд зохион байгуулах зорилгоор “Төрийн аудитын байгууллагын 2015 оны Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд “Авлигагүй хамт олон” аяныг зохион байгуулж эхлүүлээд байна.

Энэхүү аян нь жил бүр уламжлал болон зохион байгуулагдах бөгөөд Үндэсний аудитын газар болон харьяа аймаг, нийслэлийн аудитын газруудаас авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах нь тус аяныг нэг зорилт болж байна.

Цаашид авлигын эсрэг тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. [/www.audit.mn](http://www.audit.mn) сайтын авлигын эсрэг үйл ажиллагаа менюнээс үзнэ үү/

Арав. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг со- нирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2

10.1.Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх

Байгууллагын нийт ажилтан албан хаагч нарын хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, хадгалах, хянах эрх бүхий албан тушаалтныг МУЕА-ын 2014 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 18 дугаар тушаалаар томилон ажиллуулж байна.

Мөн харьяа аймаг, нийслэлийн аудитын газрын ЭБАТ-г МУЕА-ын 2014 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 251 дугаар тушаалаар томилон, хавсран гүйцэтгүүлж зохих нэмэгдлийг олгож байна. /холбогдох тушаалуудыг хавсаргав/

10.2. ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх

ЭБАТ-ын үйл ажиллагааг хавсран гүйцэтгэдэг албан тушаалтны албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтод уг чиг үүргийг тусган баталгаажуулж, мөрдөн ажиллаж хэвшээд байна. /Ажлын байрны тодорхойлолтыг хавсаргав/

10.3.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх

2015 онд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Монгол Улс дахь Улс төрийн намууд болон шүүх, хуулийн байгууллага дахь авлигын талаарх төсөөллийн судалгааны үр дүнг танилцуулах уулзалт хэлэлцүүлэг, НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ хийх албан тушаалтны сургалтад тус тус хамрагдсан. /сургалтад хамрагдсан тухай АТГ-ын ажлын хэсэгт бүргүүлсэн/

Арван нэг. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх

Эрх зүйн үндэслэл: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6

11.1.Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх

Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрмийг МУЕА-ын 2003 оны 02 дугаар тушаалаар батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Уг дүрмийг дахин боловсруулах болон шинэчлэн батлах үед саналыг авч тусган ажиллах болно.

11.2.Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/

2015 онд Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нийт ажилтан, албан хаагчдад судлуулах, мэдээлэх, дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах хүрээнд байгууллагын цахим хуудас, дотоод мэдээллийн сан болон шаардлагатай тохиолдолд нэгдсэн сүлжээгээр арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажиллаж байна. Төрийн аудитын байгууллагын ажилтны Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 40 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулан ажиллаж байна. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг журамлан зохицуулсан Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам МУЕА-ын 2015 оны 04 сарын 22-ны 121 дугаар тушаалаар батлагдан, мөрдлөг болон ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагын сургалтын хөтөлбөрийн хүрээнд Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрмийн талаар ҮАГ болон харьяа аймаг, нийслэлийн аудитын газрын нийт ажилтнуудад ахлах шинжээч З.Болд мэдээлэл хийж сурталчилан ажиллаж байна.

Арванхоёр. Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх

Эрх зүйн үндэслэл: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл

12.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх.

2014-2015 онуудад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан давхар ажил эрхэлж болох ажлын талаар нийт ажилтан албан хаагчдад бүсийн сургалт, онлайн сургалтуудаар яриа таниулга хийж ажилласан.

Давхар ажил эрхэлж болох ажил:

- хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;
- багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
- ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг.
- Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно гэж заасан.

Харин Төрийн аудитын байгууллагын ажилтны Ёс зүйн дүрмийн 2.3.8-д зааснаар Төрийн аудитын байгууллагын ажилтан албан үүргээ үр дүнтэй, бүрэн дүүрэн гүйцэтгэхэд нь харшлах өөр ажил, үйл ажиллагааг цалинтай, цалингүй хэлбэрээр ажлаас гадуур гүйцэтгэхгүй байх зохицуулалтыг тусгаж албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх чиглэлээр урьдчилсан арга хэмжээг авч, энэ талаар таниулан сурталчилж ажиллаж байна. /мэдээллийн www.audit.mn сайтын хууль эрх зүй меню-ээс үзнэ үү/

Иймд манай байгууллагад давхар ажил эрхэлдэг албан хаагч байхгүй болно.

Арван гурав. Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5

13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, төрийн байгууллагын цахим хуудаст тавигдах шаардлагын дагуу www.audit.mn сайтдаа тусгай цэс үүсгэн Тогтоол, тушаалаар батлагдсан холбогдох журам, дүрэмийг байрлуулан мэдээллийг тогтмол хийж байгаа.

13.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах

Монгол Улсын Ерөнхий аудиторын гаргасан төсөв санхүүтэй холбогдох тушаал шийдвэрийг байгууллагын цахим хуудасны шилэн данс цэсэнд, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагааг журамлан зохицуулсан эрх зүйн актыг баталсан тушаалыг цахим хуудасны хууль эрх зүй цэс, дотоод мэдээллийн санд тухай бүр байршуулан ажиллаж байна. /www.audit.mn сайтаас үзнэ үү/

13.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах

Үндэсний аудитын газрын мэдээллийн самбар, цахим хуудсанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 тогтоол, 2014 оны 20 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны 2014, 2015 оны төлөвлөгөө, 2014 оны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тайланг тус тус байршуулан иргэд танилцах, татан авч ашиглах нөхцлийг бүрдүүлсэн.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд орсон өөрчлөлтийг албан хаагчдад сурталчилсан. /мэдээлэл хийсэн бүртгэлийг хавсаргав/

Мөн төрийн аудитын байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журмын жагсаалтыг гаргаж байршуулсан. /www.audit.mn сайтын байгууллагын дүрэм журам менюнээс үзнэ үү/

13.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах

Төрийн аудитын тухай хуульд зааснаар төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит хийхэд гарсан шууд ба шууд бус зардлыг нөхөх үүднээс аудит хийлгэсэн байгууллагаас аудитын үйлчилгээний төлбөр авч болно гэж заасан. Аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жишгийг Үндэсний аудитын газрын саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтоодог бөгөөд байгууллагуудын төсөвт тусгагдсан байдаг. Төрийн аудитын байгууллагын хийсэн аудитын төлбөрийг шууд улсын төсөвт татан төвлөрүүлдэг.

/www.audit.mn цахим хуудасны шилэн данс меню-ээс үзнэ үү/

Арвандөрөв. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3; Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

14.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх

Хууль тогтоомжоор тогтоосон Төрийн аудитын байгууллагын эрхлэх асуудлын хүрээг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сургалчлан ажиллаж байна. */Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлсэн байдал, оролцсон нэвтрүүлэг, ярилцлага өгсөн жагсаалтыг хавсаргав/*

14.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)

Үндэсний аудитын газар нь өргөдөл, гомдол, хүсэлт мэдээллийг тогтмол хүлээн авах үүднээс санал хүсэлтийн хайрцаг, цахим хэлбэрээр болон бичгээр, факс, утсаар хүлээн авах боломжит бүх хувилбаруудыг бүрдүүлэн ажиллаж байна.

Мөн Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу

- Өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол зохих шийдвэрийг гаргана.
- Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал /орон сууц олгуулах гэх мэт/-аар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавина. /нийгмийн асуудал шийдвэрлэх судалгаанд хамруулж эзэнд нь хариу мэдэгддэг/
- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, зохих арга хэмжээ авсан тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгддэг.
- Хариуг амаар, харилцах утсаар мэдэгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэл үйлдэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажиллагааг явуулж байна.

14.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч үүлзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах

Үндэсний аудитын газрын цахим хуудасны холбоо барих хэсэгт ҮАГ-ын бүтцийн нэгжийн ахлах аудиторос дээш албан тушаалтны нэр, холбоо барих утасны жагсаалтыг олон нийтэд ил тод, нээлттэй байршуулсан. Мөн иргэд хүлээн авах цагийн хуваарийг Тамгын газрын даргаар батлуулан мэдээллийн самбар, цахим хуудаст, нийт ажилчдын нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар, имэйл хаягийн жагсаалтыг мэдээллийн самбарт ил тод, ойлгомжтой байдлаар байршуулсан.

Арвантав. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1

15.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх

Төрийн аудитын байгууллага нь УИХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү чиг үүргийн хүрээнд авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалд:

- Газрын дарга, тэргүүлэх аудиторууд
- Аудитын менежер
- Ахлах аудитор
- Аудитор
- Шинжээч нар багтдаг бөгөөд эдгээр албан тушаалтнууд аудитад орох бүртээ ашиг сонирхлыг зөрчилгүй мэдүүлгийг гаргаж хэвшсэн.

15.2.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/

Үндэсний аудитын газар нь хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, таниулах шинэ санал санаачлагыг бий болгох үүднээс “Авлигагүй хамт олон” аяныг зохион байгуулж эхлээд байна.

Мөн Төрийн аудитын тухай хууль, бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд сэлгэн болон шилжүүлэн томилж ажиллуулах шийдвэр гарган ажиллаж байна. Энэ үйл ажиллагаа нь авлигын эрсдэл гарах боломжийг бууруулах, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажил болж байна. 2015 онд дотоод зохион байгуулалтаар газар хэлтэс сэлгэн болон шилжүүлэн томилохоор 79 ХАСУМ-ыг хянуулж, дүгнэлт гаргуулан холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. /ХАСУМ-хянуулсан бүртгэлийг хавсаргав./

Арванзургаа. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх

Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2

16.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ

Авлигатай тэмцэх газраас 2015 оны 01 сарын 15-ны өдөр 01/333 тоот албан бичгээр Үндэсний аудитын газрын 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнг ирүүлсэн. Энэхүү албан бичгээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг ирүүлсэн.

Зөвлөмжийн мөрөөр

- Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлсэн
- Төсвийн орлого бүрдүүлэлтийг ил тод, нээлттэй болгосон
- Байгууллагын удирдлагаас гарсан төсөв санхүүгийн үйл ажиллагаа болон дүрэм журмуудыг цахим хуудсанд ил тод байршуулысан

- Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр “Авлигагүй хамт олон” аяныг эхлүүлсэн /цаашид уламлал болон зохион байгуулагдана/, албан тушаалтныг сэлгэн ажиллуулсан, ашиг сонирхлын зөрчилгүй талаарх мэдүүлгийг тухай бүр /аудит хийгдэх бүрт/ аудитор, шинжээч нараас авч ажилласан
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, олот амжилт хүрсэн үр дүнг 2015 оны ҮАГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний тайланд тусган тайлагнасан зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

16.2.АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ

АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар ямар нэгэн мэдэгдэл ирээгүй болно.

16.3. Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх

Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн дүрэм, журам, заавар гараагүй болно.

Авлигатай тэмцэх санал, санаачилга

Арвандолоо. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх

Эрх зүйн үндэслэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2;

17.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх

Үндэсний аудитын газраас Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах үүднээс 2015 оны 01 сарын 30-ны өдөр Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, төслийг Авлигатай тэмцэх газар хүргүүлэн санал авч тусган МУЕА-аар батлуулж, АТГ-т хүргүүлсэн. /Төлөвлөгөөг www.audit.mn сайтын авлигын эсрэг үйл ажиллагаа меню-нээс үзнэ үү/

Мөн Төрийн аудитын байгууллагын нийт 341 ажилтан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч, тайланг 2015 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 5/428 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

17.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх

Энэхүү төлөвлөгөөг гарган түүнийгээ хэрэгжүүлэн тайлагнаж ажилласнаар Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдах, байгууллагын үйл ажиллагаа, төсвийн орлого, түүний зарцуулалт олон нийтэд ил тод нээлттэй байх нөхцөл бүрдэж байна.

Цаашид дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, хамтран ажиллах үйл ажиллагаа эрчимжүүлэх чиглэлийг баримтлаж ажиллахаар аян зохион байгуулж ажиллаж байна.

Арван найм. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт

18.1. Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал

Үндэсний аудитын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Удирдах ажилтаны зөвлөгөөн-2015”-аар түүний харьяа аймаг, нийслэлийн аудитын газруудын удирдах ажилтнуудыг хамруулан, Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан Б.Мөнхжаргалыг урьж “Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилах, соён

гэгээрүүлэх" сэдвээр мэдээлэл хийлгэсэн. /Удирдах ажилтны зөвлөгөөний удирдамжийг хавсаргав/

Уг сургалтад нийт 31 удирдах ажилтан /Тэргүүлэх аудитор, дэд дарга/ хамрагдсан бөгөөд удирдлагуудад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийгээ байгууллага хамт олонд түгээн дэлгэрүүлж, түүнийг хэрэгжүүлэх бодлогыг чиглүүлэх талаар мэдээлэлтэй болсон.

Манай байгууллагын зүгээс дээрх зөвлөгөөнөөр удирдах албан хаагчид Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, үйл ажиллагаандаа дагаж мөрдөн, хэрэгжүүлэх мэдлэг олгосон үр дүнтэй зөвлөгөөн болсон гэж дүгнэж байна.

18.2. Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/

Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр зарцуулах хөрөнгийг холбогдох зардлын ангиллуудад зардал төлөвлөж, батлуулан холбогдох зардлыг гаргадаг. 2015 онд Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд батлагдсан 29.9 сая төгрөгөөс Авлигын эсрэг холбогдох зардлыг санхүүлэн ажиллаж байна. Мөн УАГ болон харьяа аймаг нийслэлийн аудитын газрын ЭБАТ хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг цалингийн сангаас олгож Төрийн аудитын байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

Үүнээс гадна төсөв хэмнэх үүднээс авлигын эсрэг үйл ажиллагааны талаар харьяа аймаг, нийслэлийн аудитын газруудад нэгдсэн сүлжээгээр онлайн сургалтыг зохион байгуулж шаардлагатай сургалт, мэдээллээр хангах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

18.3. Удирдлагын хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаас өгсөн үнэлгээ

Төрийн албанд хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэ шатанд хүргэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг тэдэнд олгох, шударга ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, хуулиар хүлээсэн үүргээ төгс биелүүлэх замаар авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн төлөвлөсөн хүрээнд биш байгууллага, салбар, орон нутгийн онцлогт тохирсон илүү өргөн хүрээнд зохион байгуулах зорилгоор “Төрийн аудитын байгууллагын 2015 оны Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд “Авлигагүй хамт олон” аяныг зохион байгуулж эхлүүлээд байна. Мөн бусад төлөвлөгөөт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллаж байна. /www.audit.mn сайтын авлигын эсрэг үйл ажиллагаа менюнээс үзнэ үү/

Арван ес. Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх

19.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах

Аймгийн аудитын газруудын нийт ажилтнуудад албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, Авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар онлайн сургалт хийн, мэдээлэл өгч, мөн зөвлөмж хүссэн үед тухай бүр байнга хариулт өгч ажилласан. /Мэдээлэл зөвлөгөө өгсөн тухай бүртгэлийг хавсаргав/

ҮАГ-ын эрх бүхий ажилтан Г.Өлзийдэлгэр ҮАГ болон харьяа орон нутгийн аудитын газрын 22 эрх бүхий ажилтанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, их хэмжээний өөрчлөлт, хяналт шалгалтын ажил болон худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдэд ашиг сонирхлын зөрчилгүй талаар мэдүүлгийг хэрхэн гаргаж өгөх чиглэлээр заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

19.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ

Албан хаагчдын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааг үнэн зөв шударга дүгнэх, ялангуяа ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх зарчмыг баримтлан ашиг сонирхлыг зөрчил үүссэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд ёс зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэн ажиллаж байна. Ёс зүйн зөвлөлийн ажлын баримт байгаа.

19.3.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ

ҮАГ-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ҮАГ-ын 2014 оны үйл ажиллагааны тайланд системчилсэн үнэлгээг хийсэн. Уг үнэлгээний тайланг товхимол болгон хэвлүүлж УИХ-д хүргүүлсэн бөгөөд Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралд Монгол Улсын Ерөнхий аудитор илтгэсэн.

Мөн дотоод аудитын алба “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 25/III-25/IV-ны хугацаанд хийсэн бөгөөд аудитын дүнг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитор иргэний танхимын хэлэлцүүлэгт илтгэл оруулсан.

Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн аудитын газарт ажиллаж Дотоод хяналтыг хийсэн. Дээрх хяналт шалгалтаар Авлигын эсрэг хуулийг зөрчсөн асуудал гараагүй болно.

19.4.Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ

Төрийн аудитын байгууллагын ажилтан, албан хаагчдын талаар бусад байгууллага, иргэлээс гомдол ирээгүй болно.

19.5.Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг /шүүхээр шийдвэрлэгдсэн/ ба бусад зөрчил

Төрийн аудитын байгууллагын ажилтан, албан хаагчдад АТГ-ын шалгалтаар ямар нэгэн авлигын гэмт хэрэг илрээгүй болно.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР